

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2025-04-09

Хурал хийсэн газар: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Сонсголонгийн гудамж, Монос хүнс ХК-ийн Эрүүл мэндийн хүнсний үйлдвэрийн 3 давхарт байрлах хурлын танхимд хуралдав. Хурлыг танхим цахим хосолсон хэлбэрээр компанийн албан ёсны фэйсбүүк группээр шууд дамжуулалт хийн хувьцаа эзэмшигчдийг зайнаас оролцох боломж нөхцлийг ханган хуралдав.

Эхэлсэн цаг: 10:00

Дууссан цаг: 12:30

Хурлыг зарласан: Монос Хүнс ХК

Хурлын зохион байгуулагч бүрэлдэхүүн:

Хурлын дарга: ТУЗ-ийн дарга Х.Ананд

Хурал зохион байгуулах комиссын дарга: Үйл ажиллагаа хариуцсан захирал Э.Амарболд

Тооллогын комисс: дарга П.Энхбаяр, гишүүд Ц.Дөлгөөнмайдар, Т.Энхжин

Тэмдэглэл хөтлөсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү

Хэлэлцэх асуудал:

1. Компанийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийсэн хөндлөнгийн компанийн аудитын дүгнэлтийг танилцуулах /"Онч аудит" ХХК -ийн партнер Б.Уранбилэг/
2. Ногдол ашиг хуваарилах тухай ТУЗ-ийн хурлаас гарсан тогтоолыг танилцуулах /Хурлын дарга, ТУЗ-ийн дарга Х.Ананд/
3. Компанийн 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцүүлэх /Хурлын дарга, ТУЗ-ийн дарга Х.Ананд/
4. ТУЗ-ийн 2025 оны төсвийг хэлэлцүүлэх /ТУЗ-ийн хараат бус гишүүн, Цалин урамшууллын хорооны гишүүн М.Сарандаваа/

Монос Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дарга Х.Ананд хурлыг нээж, дэгийг танилцуулан, товч мэдээлэл өгөөд Тооллогын комиссын дарга П.Энхбаярыг индэрт урив.

Тооллогын комиссын дарга П.Энхбаяр: Тооллогын комиссын тогтоол №01 уншиж танилцуулав. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 67.3.2, 67.3.8, 68.4 дахь хэсгийг тус тус үндэслэн Компанийн саналын эрх бүхий энгийн нийт 408,850,428 ширхэг хувьцаанаас саналын эрхтэй 306,711,651 ширхэг хувьцаа буюу 75.02%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд бүртгүүлж, зайнаас холбогдсон буюу танхимд өөрийн биеэр хүрэлцэн ирж оролцож байгаа тул хурлыг хүчин төгөлдөрт тооцож хурлын үйл ажиллагааг эхлүүлэв.

Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал А.Отгондарь “Монос Хүнс” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулав. Тайланг тэмдэглэлд хавсаргав.

Танилцуулах асуудал 1: Хурлын дэгийн дагуу Онч аудит ХХК-ийг төлөөлөн партнер Б.Уранбилэг “Монос Хүнс” ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн хөндлөнгийн аудитын компани Онч аудит ХХК-аас гаргасан дүгнэлтийг танилцуулав. Дүгнэлтийг тэмдэглэлд хавсаргав.

Танилцуулгад: Онч аудит ХХК-ийн товч мэдээлэл, багийн бүрэлдэхүүний хараат бус байдлаа ханган ажилласан талаар болон санхүү тайлангийн аудитын зорилго, НББ-ийн бодлогын сонголт, тооцоолол, аудитын дүгнэлтийн товч агуулга, аудитын гол асуудлууд, зөвлөмж хүргүүлсэн илрүүлэлтийн талаар мэдээлж танилцуулав.

Хэлэлцэх асуудал 1: Хурлын дэгийн дагуу хурлын дарга Х.Ананд 2024-09-09 өдөр шинээр сонгогдсон ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүн болох 11 гишүүний талаар хуралд оролцож байгаа хувьцаа эзэмшигчдэд дэлгэрэнгүй танилцуулж, ТУЗ-ийн 2024 онд хийсэн хурлын мэдээлэл, ТУЗ-аас гаргасан дагаж мөрдөж байгаа эрх зүйн баримт бичгийн талаар мэдээлж, “Монос Хүнс” ХК-ийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай танилцаад ТУЗ-өөс өгсөн дүгнэлтийг танилцуулав. Дүгнэлтийг тэмдэглэлд хавсаргав.

Танилцуулгад: 2024 онд ТУЗ ээлжит хурал 4, ээлжит бус хурал 6, тогтоол 17, ТУЗ бүрэлдэхүүн солигдсон талаар тайлагнав.

Хэлэлцэх асуудал 2: Хурлын дэгийн дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүн, Цалин урамшууллын хорооны гишүүн М.Сарандаваа 2025 оны ТУЗ-ийн төсвийн төслийг танилцуулав. Төсвийн саналыг тэмдэглэлд хавсаргав.

Танилцуулгад: 2025 оны төсвийг нэмэгдүүлж танилцуулсан бөгөөд нэмэгдэх шалтгаануудыг дурдаж хурлын зардал 12 сая, хувьцаа эзэмшигчдийн хурлын зардал 40 сая, гишүүд цалин 265,6 сая, сургалтын зардал 5 сая нийт 322,694 сая төгрөгийн төсвийг батлуулахаар санал оруулсан.

Танилцуулах асуудал 2: Хурлын дэгийн дагуу хурлын болон ТУЗ-ийн дарга Х.Ананд 2025 оны 02 сарын 19 өдрийн 25/02 тоот тогтоолоор батлагдсан “Ногдол ашиг хуваарилах тухай” тогтоолыг уншиж танилцуулав.

Тооллогын комиссын дарга П.Энхбаяр цахимаар санал хураах зааврыг дэлгэц дээр танилцуулав.

Хурлын дарга Х.Ананд: Санал хураалт өгч байх хугацаанд хурлын дэгийн дагуу асуулт хариултын цаг эхлэж байна. Хуралд оролцож байгаа та бүхэн заалнаас мөн цахимаар асуултаа чөлөөтэй асууж болно. Хувьцаа эзэмшигчдээс асуусан асуултанд ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Улаанхүү, ТУЗ-ын дарга Х.Ананд, ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Золжаргал, гүйцэтгэх захирал А.Отгондарь нар хариулт өгөв.

Хурлын дарга Х.Ананд: Дэгийн дагуу асуулт хариултын цаг дууссан байна. Санал хураалтын дүнг танилцуулна уу гээд тооллогын комиссын дарга П.Энхбаярыг урья.

Тооллогын комиссын дарга П.Энхбаяр Тооллогын комиссын тогтоол №02 уншиж танилцуулав. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.8 дахь хэсгийг үндэслэн санал хураалтад оролцсон хувьцаа эзэмшигчдийн саналын дүнг нэгтгэн танилцуулсныг доор дэлгэрүүлбээс:

Батлах асуудал 1: “Монос Хүнс” ХК-ийн 2024 оны үйл ажиллагаа, санхүүгийн тайланд өгсөн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах тухай” санал хураалтын дүн:

1. Зөвшөөрсөн – 304,463,820 ширхэг буюу 99.88% ;
2. Татгалзсан – 372,260 ширхэг буюу 0.12% ;
3. Түдгэлзсэн – 1,179 ширхэг буюу 0.001% ;
4. Санал өгөөгүй/хүчингүй- байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Батлах асуудал 2: “Монос хүнс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны төсвийг батлах” санал хураалтын дүн:

1. Зөвшөөрсөн – 304,449,150 ширхэг буюу 99.87% ;
2. Татгалзсан – 386,007 ширхэг буюу 0.13 % ;
3. Түдгэлзсэн – 2,102 ширхэг буюу 0.001% ;
4. Санал өгөөгүй/хүчингүй хуудас байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй гэсэн тогтоол уншиж танилцуулав.

Хурлын дарга Х.Ананд: Санал хураалтын дүнд үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах 01, 02 дугаарт тогтоолыг уншиж танилцуулав. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын үйл ажиллагаа 12 цаг 30 минутанд дуусав.

Тэмдэглэл хянасан:

Хурлын дарга..... Х.Ананд

Тэмдэглэл хөтөлсөн:

ТУЗ-ийн нарийн бичгийн дарга..... Н.Цагаанхүү

